



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/713

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "в", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дугаар зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны 3 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор ислам шашны сургалтын төвийн барилгын халаалтын нэмэлт ажлыг санхүүжүүлэхэд 4 000 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 4 000 000 төгрөг /дөрвөн сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.8-д Хуучирч муудсан шугам сүлжээний засвараас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ